

## ХУРАЛДААНЫ ТОЙМ

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2017 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР ХУРАЛДААН

Хуралдаан 2017 оны нэгдүгээр сарын 25-ны 14 цаг 10 минутад эхэлж, 17 цаг 26 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, 3 цаг 16 минут үргэлжлэв.

| № | Хэлэлцсэн асуудал   | Гарсан шийдвэр   |
|---|---|--|
| 1 | Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах Комиссын товч тайлан танилцуулах   |  |
| 2 | Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай               | Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйл, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдааны шийдвэр, Сонгон шалгаруулах комиссын 2017 оны НСШ/8 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн :<br>Халзанхүүгийн Батбилэгийг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэн, уг албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Монгол Улсын Засгийн газарт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов |
| 3 | Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай | Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг  |

|   |  |  |
|---|--|--|
|   |  | <p>сонгон шалгаруулах журам"-ын 32, 39 дүгээр зүйл, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдааны шийдвэр, Сонгон шалгаруулах комиссын 2017 оны НСШ/9 дүгээр дүгнэлтийг тус тус үндэслэн:</p> <p>Гэндэндарамын Эрдэнэбатыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэн, уг албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Монгол Улсын Засгийн газарт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>  |
| 4 | Барилга, хот байгуулалтын яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай | <p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 14 дүгээр зүйлийн "б", Сонгон шалгаруулах комиссын Д/2 дугаар дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>Лочингалсангийн Батжаргалыг Барилга, хот байгуулалтын яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэнд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> |
| 5 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны                                      | <p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан</p>  |

|   |   |  |
|---|---|--|
|   | <p>зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p>  | <p>тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 14 дүгээр зүйлийн "б", Сонгон шалгаруулах комиссын Д/1 дүгээр дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>Мэндбаярын Мөнхбаясгаланг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Баяртулгад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>  |
| 6 | <p>Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газрын Захиргаа удирдлагын хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p> | <p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 14 дүгээр зүйлийн "б", Сонгон шалгаруулах комиссын Д/3 дугаар дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>Намхайн Орхоныг Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газрын Захиргаа удирдлагын хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайханд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> |
| 7 | <p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газрын Виз зөвшөөрлийн газрын</p>   | <p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13</p>  |

|   |   |  |
|---|---|--|
|   | <p>дарга, Хяналт шалгалтын газрын дарга, Харьяатын газрын дарга зэрэг албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p>   | <p>дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14 дүгээр зүйлийн “б”, Сонгон шалгаруулах комиссын Д/6 дугаар дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>Чойжилдоржийн Нармандахыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газрын Виз зөвшөөрлийн газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Д.Мөрөнд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>  |
| 8 | <p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дэд дарга, Санхүү төлөвлөлтийн газрын дарга зэрэг албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p> | <p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14 дүгээр зүйлийн “б”, Сонгон шалгаруулах комиссын Д/4 дүгээр дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>Бат-Эрдэнийн Шижиржаргалыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дэд даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаярт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 болон</p> |

|    |  |  |
|----|--|--|
|    |  | <p>Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14 дүгээр зүйлийн “б”, Сонгон шалгаруулах комиссын Д/5 дугаар дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн :</p> <p>Сүхбаатарын Нацагдоржийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Санхүү төлөвлөлтийн газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Б.Нямдаваад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> |
| 9  | <p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай</p>      | <p>Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах захиалга ирүүлснийг хэлэлцээд, 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2017 оны 03 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.</p>  |
| 10 | <p>Бусад асуудал</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тогтоолд өөрчлөлт оруулах тухай</li> <li>- Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2017 оны зорилтын талаар хэлэлцэх</li> </ul> | <p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг”-ийн 4 дэх хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p>   |

|  |  |  |
|--|--|--|
|  |  | <p>“Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 196 дугаар тогтоолын 1 дэх хэсгийн “Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга,” гэснийг “Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн Ажлын албаны дарга,” гэж өөрчлөх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> |
|--|--|--|

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
АЖЛЫН АЛБА**